



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

“Барилгын хөгжлийн төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны  
эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.2, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, захирал Ц.Амарсанаатай байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаатай контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (Э.Эрдэнэхишиг)-т даалгасгай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001717